

Тусгай Зөвшөөрөл

Эрх зүй

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль;
3. Тусгай зөвшөөрлийн тухай хууль

Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл сунгуулахад бүрдүүлэх материалын жагсаалт:

1. Албан хүсэлт;
2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ / эх хувь/;
4. Эрүүл мэндийн ажилтны лиценз, дипломны хуулбар;
5. Татварын тайлан сүүлийн 3 жил;
6. Нийгмийн даатгалын тодорхойлолт;
7. Сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны тайлан;

Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл шинээр авахад бүрдүүлэх материалын жагсаалт

Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь 2 үе шаттай явагддаг.

1-р үе шат

1. Үүсгэн байгуулагчийн шийдвэр;
2. Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын барилга нь мэргэжлийн үйл ажиллагааны төсөл болон батлагдсан зураг төсвийн дагуу баригдсан, зориулалтын дагуу ашиглаж болох эсэх талаар холбогдох байгууллагаас гаргасан шийдвэр;
3. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 100 дугаар тушаалын дагуу төсөл бичиж ирүүлэх;
4. Эмнэлгийн багаж төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлт;

5. Албан хүсэлт;
6. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
7. Үүсгэн байгуулагчийн мэдээлэл ЭМС-ын 2023 оны 100 дугаар тушаалын батлагдсан хүснэгтийн дагуу;
8. Эрүүл мэндийн ажилтны мэдээлэл ЭМС-ын 2023 оны 100 дугаар тушаалын батлагдсан хүснэгтийн дагуу;
9. Тоног төхөөрөмжийн жагсаалт ЭМС-ын 2023 оны 100 дугаар тушаалын батлагдсан хүснэгтийн дагуу;
10. ЭМБ-ын байрны гадаад болон дотоод схем зураг /байршил болон дотор өрөөний зохион байгуулалт, өрөөний хэмжээг тусгасан байх/

2-р үе шат

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох аймгийн комисст гаргах хүсэлт /хаяг байршил, эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхой дурдах/;
2. Эрүүл мэндийн байгууллагын танилцуулга;
3. Компани үүсгэн байгуулагчийн шийдвэр;
4. Компаний дүрмийн хуулбар;
5. Эрүүл мэндийн байгууллагын ажиллах дүрэм;
6. Ажилтан, ажилчдын анкет /ТАХ-ын 1-р маягтаар/;
7. Компанийн захирлын ажилчдыг томилох тухай тушаал;
8. Эм зүйч, эм найруулагч, эмч, сувилагч нарын дипломын хуулбар, нотариатаар баталгаажуулах;
9. Эм барих, эмчлэх эрхийн лицензийн хуулбар, нотариатаар баталгаажуулах;
10. Хөдөлмөрийн гэрээ;
11. Албан тушаалын тодорхойлолт;
12. Иргэний үнэмлэхний хуулбар;
13. Эм ханган нийлүүлэх байгууллагатай /3-аас дээш/ хийсэн гэрээ /эмийн сан бол/;
14. Эрүүл мэндийн байгууллагын дүрэм /Эрүүл мэндийн тухай хуулийн 21.3-т зааснаас гадна байгууллагын нэр, албан ёсны хаяг, үйл ажиллагааны төрлийг тусгана /, ажиллах дотоод журам;

15. Түрээсийн гэрээ, өөрийн байртай бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
16. Ариутгал, халдваргүйтгэлийн газартай хийсэн гэрээний хуулбар хувь;
17. Хог хаягдлын гэрээ;
18. Аж ахуйн нэгжин захирал нь эмч, эмнэлгийн ажилчидтай хийсэн хөдөлмөрийн гэрээ.
19. Голомт Банкны 100020000941 дансанд 150000₮ тушаасан тухай баримт.